



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 10 (343)

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Дарьгангын Дарь овоог тахих уламжлалыг сэргээх санаачилгыг дэмжих тухай*
- *Дэчингунсэнгийн Туваанжавт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө (Засгийн газрын 2003 оны 264 дүгээр тогтоолын хавсралт)*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2004 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны гуравдугаар сарын 12 № 10 (343)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

113.	Сергей Васильевич Цыганцевийг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 04	182
114.	Дарьжэнгын Дарь овоог тахиx уламжлалыг сэргээх санаачилгыг дэмжих тухай	Дугаар 05	182
115.	Бернд Реддисийг "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 06	182
116.	Элчин сайдыг тохоон томилох тухай	Дугаар 07	182
117.	Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 08	183
118.	Б. Тунгалагсайханыг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 09	183
119.	Дэчингүнсэнгийн Туваанжавт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай	Дугаар 10	183
120.	Лхамын Батсүхэд Монгол Улсын гавьяат мал зүйч цол хүртээх тухай	Дугаар 11	183
121.	Нацагийн Дэлгэрмөрөнд Монгол Улсын хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цол хүртээх тухай	Дугаар 12	184
122.	Юндэнгийн Идэрчулуунд Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай	Дугаар 13	184
123.	Надмидын Өлзийхутагт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 14	184
124.	Дамдингийн Цэдэндоржид Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 15	184

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

125.	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө (Засгийн газрын 2003 оны 264 дүгээр тогтоолын хавсралт)		185
------	--	--	-----

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2004 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**Сергей Васильевич Цыганцевийг  
"Найрамдал" медалиар шагнах тухай**

Монгол Улсын Тагнуулын ерөнхий газар, ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын албаны хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны зөвлөх Сергей

Васильевич Цыганцевийг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н. БАГАБАНДИ**
**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2004 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

**Дарьгангын Дарь овоог тахиx уламжлалыг  
сэргээх санаачилгыг дэмжих тухай**

Монголчуудын эртний өвөрмөц нандин уламжлал болох уул овоог тайн тахиж ирсэн ёс заншил нь эх болсон байгаль дэлхий, унасан газар, угаасан усаа хайрлан хамгаалах, нутаг дэвсгэрийнхээ бүрэн бүтэн байдлыг бататган бэхжүүлэх, ард иргэдийнхээ эх оронч үндэсний үзлийг сэргээн бадраах, экологийн зөв хүмүүжил, ухамсар төлөвшүүлэх үйлдлэг сэтгэлгээг агуулдгаараа нэн чухал ач холбогдолтой билээ. Эртний түүх соёл, ёс заншил, төрт ёсны энэ эрхэм уламжлалыг даган баримталж, нутгийн ард олны санал, санаачлагыг харгалзан үзэж Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн ЗАРЛИГ буулгах нь:

1. Дарьгангын Дарь овоог эдүгээ цагийн байдал, уламжлал, шинэчлэлийн шаардлагад нийцүүлэн тахиж тайх талаар олон түмнээс гаргаж байгаа санал санаачлагыг дэмжсүгэй.

2. Тахилгын ёслолыг үйлдэхдээ төр, шашин, иргэний нийгмийн оролцоог аль болох нийтгэн хангаж, эцэг өвгөдийнхөө уугуул ёс заншил, уул овоог тайн тахиж байсан түүхэн уламжлал, орчин үеийн соёл, олон түмний дэг журмыг чандлан дагахыг нутгийн ард олон, Дарь овоог шүтэн бишрэгч нийт иргэдэд уриалсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**НАЦАГИЙН  
БАГАБАНДИ**
**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2004 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

**Бернд Реддисийг "Найрамдал"  
медалиар шагнах тухай**

Монгол Улс, ХБНГУ-ын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ХБНГУ-ын Фридрих Эбертийн сангийн монголыг хариуцсан суурин төлөөлөгч

Бернд Реддисийг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н. БАГАБАНДИ**
**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2004 оны 2 дугаар сарын 3-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

**Элчин сайдыг тохоон томилх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Тажикистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамдинжавын Дашнямьг тохоон томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**
**Н. БАГАБАНДИ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 2 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

**Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөр ажил, албан тушаалд томилогдох болсонтой холбогдуулан Бямбаагийн Тунгалагсайханыг Архангай аймаг дахь сум дундын

шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул Пүрэвдаваагийн Цэрэнбалжирыг Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 2 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

**Б. Тунгалагсайханыг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, " Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Бямбаагийн Тунгалагсайханыг Баянхонгор аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 2 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

**Дэчингүнсэнгийн Туваанжавт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай**

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж мал аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлэн, мал сүргээ өсгөж, ашиг шимийг нь нэмэгдүүлэн, малын гаралтай түүхий эдийг боловсруулан хэрэглэгчдэд нийлүүлж хоршоолол байгуулан үр ашигтай ажиллуулж, бусдыг үлгэрлэн хөдөлмөрийн онцгой амжилт

гаргаж байгааг нь үнэлж Хөвсгөл аймгийн Жаргалант сумын 3 дугаар багийн малчин Дэчингүнсэнгийн Туваанжавт Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, " Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 2 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

**Лхамын Батсүхэд Монгол Улсын гавьяат мал зүйч цол хүртээх тухай**

Хөдөө аж ахуйн байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж мал сүргийн удам угсаа, бүтцийг сайжруулах, тоог өсгөж, ашиг шим, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн

газрын малын үржлийн албаны дарга Лхамын Батсүхэд Монгол Улсын гавьяат мал зүйч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н. БАГАБАНДИ**



<p>2004 оны 2 дугаар сарын 12 -ны өдөр</p>	<p align="center"><b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b></p> <p align="center">Дугаар 12</p>	<p align="right">Улаанбаатар хот</p>
<p>Газар тариалангийн үйлдвэрлэлд олон жил үр бүтээлтэй ажиллаж үйлдвэрлэлийн технологийг чанд мөрдөн тогтвортой ургац авч, газар тариаланг хөгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын "Номунхан" ХХК-ийн дэд захирал, үр тарианы</p>	<p align="center"><b>Нацагийн Дэлгэрмөрөнд Монгол Улсын хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цол хүртээх тухай</b></p> <p>бригадын дарга Нацагийн Дэлгэрмөрөнд Монгол Улсын хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цол хүртээсүгэй.</p> <p align="center"><b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ</b></p> <p align="right"><b>Н. БАГАБАНДИ</b></p>	
<p>2004 оны 2 дугаар сарын 12 -ны өдөр</p>	<p align="center"><b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b></p> <p align="center">Дугаар 13</p>	<p align="right">Улаанбаатар хот</p>
<p>Төмөр замын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, илчит тэрэгний засварын чанар, ашиглалтыг сайжруулан үйлдвэрлэлийн даалгаврыг давуулан биелүүлэх, шинэ техник, технологи нэвтрүүлэхэд оруулж байгаа хувь</p>	<p align="center"><b>Юндэнгийн Идэрчулуунд Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай</b></p> <p>нэмрийг нь үнэлж Улаанбаатар зүтгүүрийн депогийн дарга Юндэнгийн Идэрчулуунд Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээсүгэй.</p> <p align="center"><b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ</b></p> <p align="right"><b>Н. БАГАБАНДИ</b></p>	
<p>2004 оны 2 дугаар сарын 12 -ны өдөр</p>	<p align="center"><b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b></p> <p align="center">Дугаар 14</p>	<p align="right">Улаанбаатар хот</p>
<p>Шинжлэх ухаан, боловсролын байгууллагад он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж манай орны ургамлын олон төрөл зүйлийг шинжлэх ухаанд шинээр нээн, ургамал судлалын дорвитой бүтээлүүд туурвиж, биологийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж</p>	<p align="center"><b>Надмидын Өлзийхутагт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай</b></p> <p>ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн зөвлөх Надмидын Өлзийхутагт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.</p> <p align="center"><b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ</b></p> <p align="right"><b>Н. БАГАБАНДИ</b></p>	
<p>2004 оны 2 дугаар сарын 12 -ны өдөр</p>	<p align="center"><b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b></p> <p align="center">Дугаар 15</p>	<p align="right">Улаанбаатар хот</p>
<p>Дүрслэх урлагийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаль, хүмүүсийн хөдөлмөр, аж байдлын сэдэвтэй уран болон хөрөг зураг, тайз чимэглэлийн бүтээл олныг чадварлаг туурвиж, монголын дүрслэх урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Говь-Алтай аймгийн</p>	<p align="center"><b>Дамдингийн Цэдэндоржид Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай</b></p> <p>Зураач урчуудын холбооны дарга, зураач Дамдингийн Цэдэндоржид Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.</p> <p align="center"><b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ</b></p> <p align="right"><b>Н. БАГАБАНДИ</b></p>	

## УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

(Төгсгөл, Түрүүч нь "Төрийн мэдээлэл"  
эмхтгэлийн 9 дүгээрт)

Дөрөвдүгээр бүлэг.

### МОНГОЛ УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

XXI зууны эхний 20-иод жилд унаган байгалиа хадгалах, нөөцийг нь зүй зохистой ашиглах, байгаль орчны тэнцвэрийг хамгаалах зорилго агуулсан Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт нь Монголын үндэсний газрын менежментийн хэрэгжилтийн түвшинтэй шууд хамааралтай байх болно.

Монгол Улсын орчин үеийн газрын менежмент нь өөрийн өмнө тавигдсан зорилго, зорилго агуулсан Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн түвшинтэй шууд хамааралтай байх болно.

Тэргүүлэх зорилт 1. Газрын сангийн төрийн удирдлагын чадавхийг бэхжүүлж, зарчмын шинэ түвшинд гаргах;

Тэргүүлэх зорилт 2. Газрын нөөцийн менежментийг байгаль орчны тэнцвэрийг хадгалах, хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөөцийг тэтгэн дэмжих зорилгод захируулан иж бүрэн хэрэгжүүлэх;

Тэргүүлэх зорилт 3. Үндэсний газрын мэдээллийн төв бий болгож нийгэмд үйлчлэх;

Тэргүүлэх зорилт 4. Газрын менежментийн өөрийгөө дэмжих системийг ажиллуулах.

1 дүгээр тэргүүлэх зорилт буюу газрын төрийн сангийн удирдлагын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг чухалчлан хэрэгжүүлнэ:

1.1. Төрийн өмчийн газрыг эзэмшүүлэх, ашиглуулах болон иргэнд газар өмчлүүлэх асуудлыг тэгш, шударгаар шийдвэрлэх;

Арга зам нь:

а/газрын харилцааг ардчилж, эрх зүйн орчинг бүрэлдүүлэн байнга төгөлдөржүүлнэ;

б/Монгол Улсын иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар төрийн өмчийн газраас

нэг удаа үнэ төлбөргүй өмчлүүлэх ажлыг хуулийн хугацаанд дуусгана;

в/төрийн өмчийн газраас үнэ төлбөртэйгээр өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

1.2. Газрын нөөцийг судлах, хуваарилалт, ашиглалтыг төлөвлөн зохион байгуулах үйл ажиллагааг нэгдмэл удирдлагаар хангах;

Арга зам нь:

а/Монгол Улсын газрын нөөцийг нийгмийн тухайн үеийн эрэлт хэрэгцээг судлах, үнэлэх, ашиглалт, хамгаалалт, нутаг дэвсгэрийн оновчтой зохион байгуулалтыг төлөвлөж хэрэгжүүлэх ажиллагааг газрын төрийн сангийн удирдлагын нэгэн тулгуур хэрэгсэл болгоно. 2003-2020 онд;

б/газрын нөөцийн хайгуул судалгаа, үнэлгээ, төлөвлөлтийн мэргэжлийн хүчирхэг байгууллагыг хувийн секторт бий болгоно. 2004-2007 онд.

1.3. Газрын хуваарилалт, зохицуулалт, ашиглалтад тавих төрийн хяналтыг эрхлэх;

Арга зам нь:

Газарт тавих төрийн ерөнхий хяналт, мэргэжлийн хяналт, олон нийтийн хяналтын үр дүнтэй харилцан уялдан тогтолцоог буй болгоно. 2008-2011 онд

1.4. Газрын мониторингийн сүлжээ буй болгож нэгдмэл бодлого, удирдлагаар хангах

Арга зам нь:

а/газрын мониторингийн үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулна. 2004-2007 онд;

б/газрын мониторингийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрдэм шинжилгээ туршилтын байгууллагуудыг сонгон шалгаруулж ажлыг эхлүүлнэ. 2008-2011 онд.

в/газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналт-ажиглалт, туршилтын цэг, талбаруудыг сонгон мониторинг тавьж эхлэнэ. 2008-2011 онд.



1.5. Газрын тэгш, шударга татвар, төлбөрийн тогтолцоог бүрэлдүүлж төгөлдөржүүлэх;

Арга зам нь:

а/хотожсон болон хөдөөгийн газрын зах зээлийн анхны суурь үнэлгээг хийж дуусгана. 2008-2011 онд;

б/газрын өмч болон үл хөдлөх өмчийн татварлалт, газрын төлбөрийн хууль тогтоомжийг багц байдлаар боловсруулж батлан гаргана. 2008-2011 онд;

в/бүх газар, бүх өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийг хамарсан тэгш, шударга татварын тогтолцоонд бүрэн шилжинэ. 2008-2011 он.

1.6 Олон зориулалттай газрын кадастрыг бүтээж, кадастрын үйл ажиллагааг эрхлэх;

Арга зам нь:

Газрын орон зайн болон атрибут өгөгдөл, газрын зах зээлийн ба үл хөдлөх өмчийн эрх зүйн байдлын бүртгэлийн мэдээллийг нэгдсэн бааз суурьтай мэдээллийн сангийн хэлбэрээр 2008-2011 онд байгуулж мэдээллийн менежментийг тасралтгүй эрхлэнэ.

1.7 Үндэсний хэмжээний газрын мэдээллийн систем буй болгож мэдээллийн менежментийг эрхлэх;

Арга зам:

Арга зам хэрэгслийг тэргүүлэх зорилт 3-ын хүрээнд авч үзнэ.

1.8 Газрын менежментийг дэмжих системийг зохион байгуулж тасралтгүй ажиллуулах;

Арга зам нь:

Арга зам хэрэгслийг тэргүүлэх зорилт 4-ийн хүрээнд авч үзнэ.

Тэргүүлэх зорилт 2-ын хүрээнд дараахь үйл ажиллагааг нэн чухал гэж үзэж хэрэгжүүлнэ:

2.1 Монгол үндэстний үеийн үед онцлон хайрлаж уугуул байдлаар нь хадгалан үлдээх газар нутгийн /экзобусийн/ үндэсний өвийн санг буй болгож хамгаалалтад авах;

Арга зам нь:

а/Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний сүлжээг байгуулах ажлыг дуусгана. 2016-2020 онд;

б/байгаль орчны тэнцвэрийг улсын хэмжээнд хадгалан үлдээхэд чухал үүрэгтэй газар нутаг, экзобус, Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн төрөлхтний түүх, соёл иргэншлийн үүсэл, хөгжил, мөхлийн талаархи газарт шингэсэн мэдээлэл, газар дэлхийн гарал үүсэл, хөгжил, өөрчлөлттэй холбоотой чухал мэдээллийг агуулсан газрууд, үндэстэн ястан, орон нутгийн хүн ардын тахин шүтэж, нандигнан хадгалах эрмэлзэлтэй байгалийн объект, газрыг бүртгэн газар нутгийн үндэсний өвийн сангийн реестр буй болгоно. 2008-2011 онд.

2.2 Давуу байдлыг нь тэтгэн дэмжсэн хөгжлийн онцгой бичил бүсүүдийн аргаар газар нутгаа хөгжүүлэх;

Арга зам нь:

а/улс орныг батлан хамгаалах болон үндэсний хэмжээний хөгжилд тодорхой чиг үүрэг гүйцэтгэж чадах нөхцөл, нөөц бүхий сав нутаг, байгаль нутаг дэвсгэрийн районуудад давуу байдлыг нь тэтгэн дэмжсэн хөрөнгө оруулалт, менежментийн бодлогыг төрөөс хэрэгжүүлнэ;

б/чөлөөт эдийн засгийн бүсүүдийг бүх хэлбэрээр нь байгуулна;

в/дэлхийн хүн амын хүнсний хангамжид зохих хувь нэмэр оруулж чадахуйц чадавхитай бөгөөд монголчууд өөрсдийн хүч хөрөнгөөр ойрын 10 жилд эзэмшиж чадахгүй газар нутгийг гадаад улсуудад тусгай болзолтой гэрээгээр 60-99 жилээр түрээслүүлнэ. 2012-2015 онд.

2.3 Хот, суурин газрын төлөвлөлт, газар олголтыг орон зайн зарцуулалт, оршин суугчдын нягтралыг харгалзсан нормативтай системд шилжүүлэх;

Арга зам нь:

а/бүх хот, тосгон, суурины тэгш гортигийг газар зохион байгуулалтын журмаар тогтоож, бусад ангиллын газраас хатуу зааглана. 2008-2011 онд;

б/орон сууц, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, соёл боловсрол, албан газрын конторын зориулалт бүхий барилга байгууламжуудад дэвсгэр газрын нэгж талбайд ногдох барилгын нийлбэр талбайн доод хэмжээнд үндэслэсэн давхарлалын коэффициент тогтооно. 2004-2007 онд;

в/боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагад ногдох газрын хэмжээг бүсийн байдалтай уялдуулан тогтоох, ялангуяа нийслэл болон томоохон хот, суурин газарт үйл

ажиллагаагаа явуулж буй бүх шатны сургууль, цэцэрлэгийн эзэмших газар, биеийн тамир, туршилт, судалгаа, үйлдвэрлэлийн талбайг оюутан, сурагч, ажиллагсдын тоо, үйл ажиллагааны онцлог, хэтийн чиглэлээс нь хамруулан нарийвчлан тогтоож өгнө. 2004-2007 онд;

г/их сургуулиудыг кампус хэлбэрээр хөгжүүлж буй дэлхийн жишгийг харгалзан кампусын газрын асуудлыг хөхиулэн дэмжиж, тухайн сургуулийн хэтийн төлөвтэй уялдуулан эн тэргүүнд шийдвэрлэж байхын сацуу туршилт, судалгаа, үйлдвэрлэл явуулах талбайг иж бүрэн байх зарчмыг баримтална. 2004-2007 онд;

д/эрдэм шинжилгээний байгууллагын эдэлбэр газрыг үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан цогц байдлаар шийдвэрлэнэ. 2004-2007 онд;

е/хүн амын орон байрны бүсүүдэд нэг оршин суугчдад ногдох газрын нормативыг тогтооно. 2004-2007 онд.

2.4. Хот, тосгон, суурингуудад хүн эрүүл, аюулгүй, хүлцэхүйц тохиромжтой орчинд амьдрах нөхцөлийг хангах;

Арга зам нь:

а/хот, тосгон, суурингуудын зохион байгуулалт, барилгажилт, тохижилт, экологийн нөхцөл байдалд аудит болон бенчмаркингийн (benchmarking) аргаар дүн шинжилгээ хийнэ. 2008-2011 онд;

б/шаардлагатай хот тосгодоод хот байгуулалтын реконструкци хийнэ. 2012-2015 онд;

в/хүн амын төвлөрөл /нягтрал/ ихтэй томоохон хот тосгодын орчны бүс нутгийн байгаль, орчны тэнцвэрийн чадавхид үнэлгээ өгч, ашиглалтын зориулалт, ачааллын зөвшөөрлийн системийг нэвтрүүлнэ. 2008-2011 онд.

2.5. Мал аж ахуй, газар тариаланг байгаль орчинд халгүй арга технологиор эрхлэх аргад шилжих;

Арга зам нь:

а/бүс нутаг бүрээр байгаль орчны тэнцвэрийг хадгалах зорилгыг 1 дүгээрт тавьсан газрын менежментийг бүрэн нэвтрүүлнэ. 2004-2007 онд;

б/газар тариаланд хөрсний үржил шимийн өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийн аргыг бүрэн нэвтрүүлнэ. 2008-2011 онд;

в/газар хамгаалах шаардлагад бүрэн нийцсэн газар тариалангийн арга технологи нэвтрүүлнэ. 2011-2015 онд.

2.6. Цөлжилтэд нэрвэгдсэн болон цөлжилтийн үйл явцад байгалийн аясаар нэрвэгдэх магадлалтай газар нутгуудад цөлжилттэй тэмцэх бодит үйл ажиллагааг эрчимжүүлэх;

Арга зам нь:

а/хөрс тогтворжуулах болон ургамлан нөмрөгийг хадгалан хамгаалах зорилгоор цөл, цөлөрхөг хээрийн экосистемийн нөхцөлд ургаж байгаа унаган мод, сөөг, бутлаг ургамлуудыг ногоон бүс, зурвас, ногоон арал, ногоон хучлага зэрэг хэлбэрээр тариалж ургуулах замаар газрын тусгаг бүрхэвчийн хувийг 45-аас багагүй хэмжээнд хүргэнэ. 2007-2015 онд.

2.7. Эрдэс баялаг, зам, шугам сүлжээ, барилгын үйлдвэрлэл, батлан хамгаалах салбарт ашиглалтын дараахь газрын нөхөн сэргээлтийг бүрэн хийж аж ахуйн эргэлтэд оруулдаг зарчмыг үе шаттайгаар тууштай нэвтрүүлэх.

Тэргүүлэх зорилт 3-ын хүрээнд нэн түрүүнд дараахь үндсэн үйл ажиллагааг явуулна:

3.1. Үндэсний газрын мэдээллийн системийг техник төхөөрөмжийн; программ хангамжийн; мэдээллийн сан хөмрөгийн; хүний нөөцийн дэд системүүдтэйгээр байгуулна. Эхний ээлжийг 2004-2007 онд;

3.2. Газрын сангийн данс бүртгэл, газар зохион байгуулалтын шугамаар бүрэлдүүлсэн газар ашиглалт, зохион байгуулалт, зохицуулалтын болон хөрс, бэлчээрийн цаасан дээр байгаа зураг мэдээллийг тоон мэдээлэлд шилжүүлнэ. 2004-2007 онд;

3.3. Улсын хэмжээгээр газрын нөөц, ашиглалтын орон зайн орчин үеийн мэдээллийг тандан судалгааны аргаар бүрэлдүүлнэ. 2008-2011 онд;

3.4. Газрын кадастрын зураглал болон бүртгэлийн мэдээллийг эхнээс нь тоон мэдээллийн горимоор гүйцэтгэж эхлэнэ. 2004-2007 онд;

3.5. Газрын мэдээллийн сан хөмрөгийг бүрдүүлсний дараа хот байгуулалт, дэд бүтэц, уул уурхай, байгаль орчин, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн, батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах мэдээллийн сантай мэдээлэл солилцооны горимд шилжинэ. 2011-2015 онд;

3.6. Үндэсний газрын мэдээллийн системийн хүний нөөцийн чадавхийг бүрдүүлэх



сургалт, дадлагууулалтын бие даасан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ. 2004-2007 онд.

Тэргүүлэх зорилт 4-ийн хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1. Тогтвортой газрын менежментийн шинжлэх ухаан-арга зүйн дэмжлэгийг буй болгож хөгжүүлэх;

Арга зам нь:

а/байгаль, нийгмийн экологигжсон харилцааны нөхцөл дэх газрын менежментийн онол-арга зүй, төлөвлөлт, төсөлжүүлэлт, зохицуулалтын норм, нормативын баазыг буй болгоно. 2008-2011 онд;

б/газрын менежментийн эрдэм шинжилгээ, туршилт, сорилтын хүчирхэг байгууллагыг төрийн дэмжлэг оролцоотойгоор хувийн секторт түшиглэн буй болгоно.

4.2. Мэдээллийн менежмент бүхий мэдээллийн сан буй болгох;

Арга зам нь:

а/газрын нөөц, чанар, төлөв байдал, үнэлгээ, өмчлөлт, эзэмшилт, ашиглалт, хамгаалалтын талаархи байнга шинэчлэгдэж байдаг мэдээллийн баазыг буй болгоно. 2004-2007; 2008-2011 онд;

б/газрын менежментийн төв, орон нутгийн салбаруудын хооронд болон нийгмийн үйл ажиллагааны бусад салбаруудын хооронд мэдээлэл солилцооны сүлжээтэй болно. 2011-2015 онд.

Тайлбар: Тэргүүлэх зорилт 3-ыг хэрхэн хэрэгжүүлснээс 4.2-т заасан үйл ажиллагаа хамаарна.

4.3 Тогтвортой газрын менежментэд шаардагдах хүний, материалын, мэдээллийн, санхүүгийн нөөцийг буй болгож байнга хөгжүүлэх;

Арга зам нь:

а/орчин үеийн газрын менежментийн үйл ажиллагааны салбаруудын онол-арга зүйг эзэмшсэн мэргэжилтнүүдийг шаталсан сургалтаар дагнан бэлддэг, давтан сургадаг чиг үүрэгтэй үндэсний дээд сургуультай болно. 2007-2011 онд;

б/газрын менежментийн төв, орон нутгийн салбаруудыг газрын менежментээр

мэргэшсэн хүний нөөцөөр бүрэн хангана. 2011-2015 онд;

в/газрын менежментийн төв, орон нутгийн салбаруудыг газрын нөөцийн судалгаа, зураглал, хэмжилт, боловсруулалт, мэдээлэлжүүлэлтийн хөгжингүй технологи бүхий шинэ үеийн багаж, техник хэрэгсэл, багц програмуудаар хангана. 2007-2011 онд;

г/газар өмчлөх, эзэмших, ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх хүрээнд газар, газарт суурилсан эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус харилцааг зохицуулах эрх, эрх зүйн зохицуулалтын орчинг бүрдүүлж хөгжүүлнэ. 2004-2007 онд;

д/газрын менежментийн гүйцэтгэх чиг үүрэг, үйл ажиллагааны процедур, газрын менежментийн байгууллага, албан тушаалтны эрх хэмжээг тогтоох, бэхжүүлэх эрх зүйн орчинг хөгжүүлнэ. 2004-2007 онд.

4. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх газрын менежментийн үндсэн асуудлуудыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл

4.1 Эрх зүйн тогтолцооны хөгжил

Газрын менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн тогтолцооны механизмыг одоо үйлчилж буй бөгөөд нийгмийн хөгжлийн аясаар гарч ирэх, гүнзгийрэх харилцаанд зохицуулан өөрчлөх, төгөлдөржүүлэх, нийгмийн харилцаа, түүний эрэлт хэрэгцээтэй уялдан шинээр боловсруулж гаргах асуудал зүй ёсоор тавигдах юм.

4.2 Санхүүгийн эх үүсвэр, механизм

Газрын менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр, механизмд уламжлалт төсвийн урсгал санхүүжилт, улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаас гадна газрын татвар, төлбөрийн орлогоос газрын менежментийн арга хэмжээг санхүүжүүлэх хувь хэмжээг нэмэгдүүлнэ.

Үндэсний газрын мэдээллийн сан байгуулах, орчин үеийн газрын менежментийн үйл ажиллагааны салбаруудын онол-арга зүйг эзэмшсэн мэргэжилтнүүдийг шаталсан сургалтаар дагнан бэлддэг, давтан сургадаг чиг үүрэгтэй үндэсний дээд сургууль, газрын менежментийн эрдэм шинжилгээ, туршилт, сорилтын хүчирхэг байгууллага байгуулах эзрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд гадаад, дотоодын хувийн сектортой хамтарсан хөрөнгө оруулалт хийх, олон улсын байгууллагын шугамаар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх эзрэг механизмыг ашиглана.

## 4.3 Бүх нийтийн оролцоо

Газрын менежментийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ард иргэд, байгаль орчин, газрын салбарын төрийн бус байгууллага, гадаад орнуудын газрын менежментийн болон байгаль орчны мэргэжлийн төрийн ба төрийн бус байгууллага, хувь хүмүүсийн оролцоо маш чухал гэж үзнэ.

Ялангуяа газрын үндэсний өвийн сан байгуулах, хадгалан хамгаалах, газрын хууль тогтоомжийн биелэлт, газрын төлөв байдал, чанар, газар нөхөн сэргээлтэд тавих хяналтын нэг хэсэг нь төрийн бус байгууллага, орон нутгийн ард иргэдийн идэвхитэй үйл ажиллагаанд түшиглэж амжилтад хүрнэ гэж үзнэ.

## 4.4 Гадаад бодлого

Монгол Улсын газрын менежментийн бодлого нь дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө болон түүний хүн ардад нээлттэй байна. Нээлттэй байх зарчмыг дараахь чиглэлд хэрэгжүүлнэ:

Монгол орны унаган төрхөө харьцангуй хадгалан үлдсэн янз бүрийн хэв шинж бүхий өргөн уудам нутаг дэвсгэр, түүний биологийн олон янз байдал, төрөл зүйлс, байгальтайгаа хүйн холбоо нь тасраагүй аж төрлийн хэв шинж зэрэгтэй чөлөөтэй танилцуулах нөхцөлөөр хангана.

Хяагааргүй уудам орон зай-унаган байдалтай ландшафтын хослолыг рекреацийн зорилгоор хүртэхэд нээлттэй байна.

Монголын хөрс шороо, ургамлан нөмрөгийн онцлог, давуу талыг ашиглан байгалийн уураг, амин дэмээр баян, экологийн цэвэр орчинд бүтсэн экспортод гаргах хүнсний бүтээгдэхүүн, орцын материал үйлдвэрлэхэд газраа чөлөөтэй олгоно.

Монголчууд өөрсдийн хүч хөрөнгө, технологиор аж ахуйн эргэлтэд оруулж чадахгүй байгаа зарим бололцоотой газар нутгуудыг гадаад улсын засгийн газарт тусгай болзол нөхцөлтэй гэрээгээр эзэмшүүлэхэд бодлогын хувьд нээлттэй байна.

Газрын гүний усны ордуудыг түшиглэн говь цөлийн бүсэд хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн өндөр түвшинд хүрсэн бичил суурьшлын бүсүүдийг гадаад орны ажиллах хүчин, хөрөнгөөр буй болгохыг хөхиүлэн дэмжинэ.

Газрын менежментийн техник, технологийн шинэчлэл хийхэд олон улсын байгууллага, гадаад улсын тусламж дэмжлэг, хөрөнгө оруулалтын механизмд тулгуурлана.

5. Газрын менежментийг хэрэгжүүлэх үндсэн үе шат, гарах гол үр дүн

### 5.1 Хэрэгжүүлэх үндсэн үе шат

Газрын менежментийн үндсэн асуудлуудыг хэрэгжүүлэх хугацааг төсөөлөхдөө дэвшүүлэн тавьж буй зорилтуудын хоорондын цаг хугацааны уялдаа, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга замын цар хүрээ, ажлын түвэгшил зэргийг харгалзсан бөгөөд гэхдээ зорилтуудын хоорондын цаг хугацааны уялдааг голлон анхаарсан.

### 5.2. Гарах гол үр дүн

Газрын менежментийг хэрэгжүүлснээр газрын талаар төрөөс тогтвортой баримтлах бодлого буй болно.

Тэргүүлэх зорилт 1-ийг бүрэн хэрэгжүүлснээр:

а/газрын санг төрөөс удирдах удирдлага чиг үүргийн хувьд иж бүрэн болж, онол аргачлал, арга хэрэгслийн хувьд менежментийн шинжлэх ухааны түвшинд хүрнэ;

б/газрын кадастрын зураглалаар дэмжигдсэн газрын эрхийн бүртгэл (газрын эрхийн кадастр) буй болж үл хөдлөх өмчийн харилцаа хөгжих эрх зүй-мэдээллийн таатай орчин бүрдэнэ; в/байгаль орчин, нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн газрын менежментийн арга ухааныг эзэмшсэн мэргэшсэн хүний нөөцтэй болно;

г/хөгжингүй техник, технологид суурилсан олон зориулалттай газрын кадастрыг бүтээнэ. Ийм кадастр эрхлэх мэдлэг, ур чадвар бүхий хүний нөөцтэй болсон байна;

д/байгалийн нөөц, баялгийг эзэмших, ашиглах, хамгаалах үйлс экологигжиж, хүмүүнлэг болоход томоохон алхмууд хийгдэнэ.

Тэргүүлэх зорилт 2-ыг бүрэн хэрэгжүүлснээр:

а/монгол орны газрын нөөцийг хадгалан хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөөцийг тэтгэн дэмжих зорилгод газрын менежмент бүрэн чиглэгдэнэ;

б/газар нь өмчлөлийн зүйл, бизнесийн объект, байгалийн нөөц баялгийн үүргийг нэгэн зэрэг биелүүлж, эдийн засгийн эргэлтэд олон арга замаар өргөн хүрээтэй оролцуулах боломж бүрдэнэ;



в/Монгол Улсын тусгаар тогтнолд хохирол учруулахгүйгээр ашиглалтгүй болон хангалттай ашиглах эдийн засгийн чадавхи хүрэхгүй байгаа газар, газар нутгийг дэлхийн хамтын нийгэмлэг, гадаад улс, гадаад орны иргэд, аж ахуйн нэгжтэй хамтран аж ахуйн эргэлтэд оруулж үр шимийг нь улам өргөн хүрээтэй хүртэж эхэлнэ;

г/газар ашиглалтад бүслэл, зөвшөөрөл, хязгаарлалт, болзолтой ашиглалт зэрэг менежментийн зарчмыг нэвтрүүлснээр газар ашиглалтаар дамжуулан байгаль орчны тэнцвэрийг хангах болон хүний эрүүл, аюулгүй нөхцөлтэй газар зүйн орчинд амьдрах боломжийг хангахад ахиц гарна;

д/газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийг байгаль орчны тэнцвэрт байдалд халгүй арга барилаар эрхлэх, байгаль-нутгаг дэвсгэрийн биочадавхи, даацад тохируулан нормчлогдсон ачааллын зарчмаар бэлчээр нутгийг ашиглах горимд орж эхэлнэ;

е/газар ашиглалтын нутаг дэвсгэрийн бүтцэд зарчмын өөрчлөлт орж эдийн засгийн мезо, микро бүсүүд болон хөгжлийн голомтууд ялгаран гарна.

#### Тэргүүлэх зорилт 3-ыг хэрэгжүүлснээр:

Монгол Улс нийтийн зориулалттай үндэсний газрын мэдээллийн сантай болж нийгмийг үйлчлэх бөгөөд буй болгосон мэдээлэл нь байгалийн нөөцийн ашиглалт, байгаль орчны хамгааллын менежментийн хүчирхэг хэрэглүүр болон ашиглагдана. Үндэсний газрын мэдээллийн сантай болсноор газрын зах зээлд хяналт-шинжилгээ хийх, газрын харилцаанд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, газрын татавар, төлбөр ногдуулах, хураах үйл ажиллагааг мэдээллээр дэмжих зэрэг олон талын ач холбогдолтой. Үндэсний газрын мэдээллийн сангийн мэдээлэл нь өөрөө эргээд баялаг бүтээх баялаг болох болно.

#### Тэргүүлэх зорилт 4-ийг хэрэгжүүлснээр:

Газрын менежментийг дэмжих системийг бүрэлдүүлж тасралтгүй ажиллуулснаар газрын сангийн төрийн удирдлагыг тогтвортой, үр ашгитай, нийгмийн тухайн үеийн социаль болон эдийн засаг, байгаль орчны менежментийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн явуулах боломж гарна.

6. Газрын менежментийн үндсэн асуудлуудын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний товч агуулга

Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх амин чухал хүчин зүйл нь хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилт, үйл ажиллагааны биелэлт болон үр дүн, түүний үр нөлөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байх явдал юм.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ нь газрын менежментийг дэмжих системийн үйл ажиллагаанд буюу хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын хүрээнд багтана. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг дараахь асуудалд голлон чиглүүлнэ.

Үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөнд мониторинг тавина.

Газрын төлөв байдал, чанар, хэмжээ, газрын сангийн бүтцэд мониторинг тавина.

Газрын хууль тогтоомжийн хэрэгжилтэд ерөнхий болон мэргэжлийн хяналт, олон нийтийн хяналтыг хослуулан тавина.

Газрын кадастр бүтээх, эрхлэх үйл ажиллагаа, үр дүнд бенчмаркинг /Benchmarking/ хийнэ.

Үндэсний газрын мэдээллийн системийн техник, технологи, үйл ажиллагааны түвшинд бенчмаркинг хийнэ.

Газрын менежментийн төв, орон нутгийн салбар, нэгжүүдийн үйл ажиллагаанд SWOT үнэлгээ хийнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх гадаад, дотоод орчны хүчин зүйлсийн өөрчлөлт, нөлөөлд үнэлгээ өгнө.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг харгалзан шаардлагатай бол хөтөлбөрийн зорилго, зорилт, үйл ажиллагаанд тодотгол хийж болохоос гадна менежментийн шийдвэр, хэрэглэж буй арга хэрэгсэл зэрэгт өөрчлөлт оруулах, засвар, засал хийх ажиллагаанд уян хатан хандаж байх нь амжилтын үндэс болно.

7. Үндсэн асуудлуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тухай

Энэхүү төлөвлөгөөнд үндэслэн тухайн үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны арга хэмжээний төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, хэрэгжүүлэх зарчмаар явах нь зүйтэй гэж үзэж байна.

## Газрын менежментийн үндсэн асуудлуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө

Хүснэгт №25


№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Харниулах байгууллага
Төлөвлөлтийн сөрөн үед /2004-2010 он/		
1	Үнэ төлбөргүй газар өмчлөх уйл ажиллагааг хэрэгжүүлэх	Засгийн газар
2	Дуудлага худалдаагаар болон давуу эрхээр үнээр нь худалдаж газар өмчлөх уйл ажиллагааг үргэлжлүүлэх	Засгийн газар
3	Газрын нөөцийн хайгуул судалгаа, үнэлгээ, төслийн мэргэжлийн байгууллагыг бий болгож ажиллуулах	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, уусгэн байгуулагчид
4	Газрын кадастрын зураглалын ажлыг дуусган, бүх газрыг газрын эрхийн бүртгэлд заавал хамруулах арга хэмжээ авах	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
5	Хот, тосгон, суурингуудын суурьшлин бүс газрын хил заагийг тогтоож бусад зориулалтын ангиллын газраас зааглаж өгөх	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
6	Төрөл бүрийн зориулалтаар газар олгоход баримтлах нормативыг боловсруулж мөрдөх	Дэд бүтцийн яам, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
7	Нийслэл хот, аймаг, сумын төвүүдийн хот, тосгоны орчин газрын байгаль орчин гэнцэрлийн чадавхийг үнэлгээ өгч даашиг нормцол ашиглах аргад шилжих	Байгаль орчин яам
8	Газрын менежментийн баталсан сургалт, давтан сургалт бүхий дээр сургууль байгуулж, байгаль орчин, газрын менежментийн салбарыг мэргэжсэн хүний нөөцөөр хангах	Байгаль орчин яам, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
Төлөвлөлтийн дунд үед /2011-2015 он/		
9	Байнгын ажиллагаатай газрын мониторинг үүсгэн байгуулах	Газрын менежментийн мэргэжлийн байгууллага
10	Газрын татвар, төлбөр, нөхөн олговрын зөрлөгөөр газарт эдийн засгийн үнэлгээ өгөх	Газрын менежментийн мэргэжлийн байгууллага
11	Үндэсний хэмжээний газрын мэдээллийн нэгдсэн сан зохион байгуулах	Засгийн газар
12	Хөгжлийн төлөвлөлт "синглов" бүс байж чадах газруудыг илрүүлж үнэлэх, хөгжлийн төсөл хөтөлбөрийг боловсруулах ажлыг зохион байгуулах	Санхүү, эдийн засгийн яам, Байгаль орчин яам
13	2000-аас дээш хүн амтай хот, тосгоны нүүлэн байгуулалт, барилгачилт, хүн амьдрах газар зүйн орчинд аудит, бичиг үргийг хийж, холбогдох арга хэмжээ авч эхлэх	Байгаль орчин яам
14	Байгаль-нутаг дэвсгэрийн бүс районы онцлогт тохируулсан бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, нэвтрүүлэх	Байгаль орчин яам
15	Газрын менежментийн төв, орон нутгийн нэгжүүдийг газрын хайгуул судалгаа, хэмжилт боловсруулалтын хөгжингүй технологийн багцад тохоромжөөр хангах	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
Төлөвлөлтийн эцэст үед /2016-2023 он/		
16	ТХХГ-ийн үндэсний сүлжээг байгуулах ажлыг тусгай хөтөлбөрийн үндсэн дээр хэрэгжүүлж дуусгах	Байгаль орчин яам
17	Газар нутгийн үндэсний өвийн сангийн реестр буй болгож хадгалан хамгаалах арга хэмжээг зохион байгуулах	Байгаль орчин яам, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
18	Чөлөөт эдийн засгийн бүс, концессийн гэрээний үндсэн дээр гадаад улс, гадаадын хуулийн этгээдэд ашиглуулах газруудыг сонгон авч, техник-эдийн засгийн үндэслэлийг гаргах	Санхүү, эдийн засгийн яам, Байгаль орчин яам
19	Цөл, цөлөрхөг хээр нутаг болон цөлжилтөд нэрвэгдсэн газруудад ургамлан нөмрөг буй болгох ажлыг тусгай хөтөлбөрийн үндсэн дээр өргөн хүрээтэй эхлүүлэх	Байгаль орчин яам

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн агуулга нь М1:1000 000 масштабын 2 зураг, 11 бүлэгт хамрагдах 53 хүснэгт, М1:6 500 000-ын масштабын 43 зураг бүхий 136 хуудас нэгдсэн тайлбар бичиг, газрын менежментийн бодлогын бүс бүрээр боловсруулсан 14 боть төрөлжсөн тайлан, түүнд хамаарах М1:1000000-ын масштабын 8 зураг, М1:100000-ын масштабын төлөвлөлтийн 9 зурагт тусгагдсан болно.

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний боловсруулалтын үр дүнд улсын хэмжээний бүх 1:100 000-ны байр зүйн зураг (1300 хуудас зураг) болон төлөвлөлтийн дээр дурдсан зургууд тоон хэлбэрт шилжин электрон картын хэлбэрээр CD-д бичигдэн Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын мэдээллийн санд орсон болно.

зураг 1

## БАЙГАЛЬ НУТАГ ДЭВСГЭРИЙН МУЖУУД



зураг 2

## Хөдөө аж ахуйн газрын хэтийн төлөвлөлт



М 1:6500000

2003 он

ТАНХ ТЭМДЭГ

\* Аймгийн төв, хотууд

Улсын хил

Аймгийн хил

Тойргийн хил

Хадлангийн талбайн байршил

Тармалангийн талбайн байршил

Сүүний эрчимсэн аж ахуйн тойрог


Услагатай нөхцөлд буудайн үйлдвэрлэл эрчимтэй эрхлэх тойрог

Услагатай нөхцөлд буудайн үйлдвэрлэл эрчимтэй эрхлэх тойрог

Нутгийн шилжэл омгийн сайжруулагч ашиглах хагас суурин мал аж ахуйн тойрог

Зураг 3

## МОНГОЛ ОРНЫ БЭЛЧЭЭР УСЖУУЛАЛТЫН ТӨЛӨВ



### ТАНИХ ТЭМДЭГ

- гол
- уссын хил
- аймгийн хил
- бэлчээр усжуулалт эрчимтэй хийх гол район
- усжуулагдсан бэлчээр
- бэлчээрт тохиромжгүй болон ашиглагдажгүй бэлчээр
- усжуулагдаагүй бэлчээр
- ой
- нуур

Зураг 4

## УСАЛГААТАЙ ГАЗАР ТАРИАЛАНГИЙН БАЙРШИЛ



### ТАНИХ ТЭМДЭГ

- элэг гаж буй усалтын систем
- саяг олодох усалтын систем
- замгийн тус
- гол
- зөвгөөр өм зэлт
- угсын зэлт
- нуур



Зураг 4а

## УСАН ЦАХИЛГААН СТАНЦУУДЫН БАЙРШИЛ



### ТАНИХ ТЭМДЭГ


- одрын цэвэр усны ашигласан төлөвлөсөн
- ▲ усны төлөвлөсөн үндэс
- ашиглаж буй үндэс
- аюулгүй тус
- ∩ гол
- ∪ аюулгүй хил
- ∩ ууслын гал
- муур



## ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ОЙН ТӨЛӨВЛӨЛТ /2003-2023 он/



зураг 6




- Урвйн хил
- Адгийн хот
- Адгийн төв
- Суурин төв
- ГСН
- НУУР
- Суурин хил
- ОАА-н эрэг зэмлэх
- Түүхийн зузаас
- Арчиглаа
- Ашиглалт
- Ойжуулалт
- Төлөөлөлт
- Ногоон бүс
- Ногоон төгөт сайруулах
- Хамгааллын ойн зузаас
- Тусгай хамгаалалтад авах ой
- Хэрэглэн устгах ой
- Иргэдийн мурдал
- Дэлгэцнүүд
- Бөөр байрлалын муж
- Төв Адгийн муж
- Ой
- Хус улсаас
- Газруур жарро
- Хүн
- Шинэс
- Зар
- Нэгж
- Зөвхөн дэргэйн бүс
- Баруун бүс
- Хамгаан бүс
- Төвийн бүс
- Зүүн бүс
- Улаанбаатар бүс

Масштаб 1:5227407


## ДЭД БҮТЦИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗРЫН БАЙРШИЛ

зураг 7



зураг 8

## Эрчим хүчний шугам сүлжээний газрын байршил




Мэсшлэб 1:6500000



- ★ Танигд тэжээдэг утлын нийслэл
- Булагд түгээр төм
- Аймгийн төв
- Урд зүгээрлэл хөдөөд суурин
- Төлөө мөхөөд дамждаг суурин
- ⚡ Дулааны цахилгаан станц
- ⊠ Хоёр цахилгаан станц
- ✱ Аймгийн дизель станц
- ~ Эрчим хүчний шугам сүлжээ
- ⚡ Төлөө мөхөөд дамждаг цахилгаан станц
- ⊠ Төлөө мөхөөд усан цахилгаан станц
- ⊠ Төлөө мөхөөд 30 чийг хүний шугам сүлжээ
- 400 кВТ
- 220 кВТ
- 110 кВТ
- 35 кВТ
- 20 кВТ

## Холбоо мэдээллийн шугам сүлжээний газрын байршил

зураг 9




- Танх тэмдэг**
- ★ Улсын нийслэл
  - Бусийн тулгуур төв
  - Аймгийн төв
  - ▲ Телевлесен нисэх буудал
  - ∩ Шилэн кабель
  - ∩ Холбооны шугам
  - ⚡ Радио релей-ий станц

Масштаб 1:55000 000


зураг 10

Авто ба төмөр замын зурвас газрын байршил



Масштаб 1:6000000

ОЙРЫН ИРЭЭДҮЙД АШИГЛАНДАХ ОРД ГАЗРУУД, ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БҮС ГАЗРУУДЫН БАЙРШИЛ зураг 11









ТАНИХТЭМЦЭГ

зураг 14

- ▲ дотгоо тос
- ▲ урлагийн хот
- ▲ аймгийн төв
- Чөлөөтэй эвэлдэг орнууд, шилэн жоргооллын бүс
- Чөлөөтэй эвэлдэг орнууд, шилэн жоргооллын бүс
- уур
- эрэг


БҮСҮГДИЙН ОР

Амралт сувилал, аялал жуулчлалын

цэн нутаг 2010 он зуртал

1. Төвийн бүс
12. Улаанбаатар орчимын
16. Алтайн бүс, Түркийн хэвс орчимын
18. Булган, Завхант орчимын
2. Хэнтийн нурууны бүс
- 2а. Хэнтийн, Шаргалзурт, Хөвсгөл-Төвийн шилэн нуур орчимын
- 2б. Очирхонго уул, Тугалж нуур орчимын
3. Говьын бүс
- 3а. Говийн ордон, говь, гравий сайрагт орчимын
- 3б. Дунд ордон их булз ихэдэн чэрүү орчимын
- 3в. Саймалца-Завхан Түрдийн бүс

## АМРАЛТ СУВИЛАЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МҮЖЛАЛ



БҮСҮГДИЙН НСР

Амралт сувилал, аялал жуулчлалын

цэн нутаг 2010 он зуртал

4. Хэнтийн бүс
- 4а. Иргэн-Хөвсгөл орчимын бүс
- 4б. Дундхан бүс, Говь-Алтай бүс, Хөвсгөл бүс
- 5а. Ойгоо-Хөвсгөл бүс, Хөвсгөл-Завхан тусгай захиргааны бүс
- 5б. Хөвсгөл-Хөвсгөл бүс

Амралт сувилал, аялал жуулчлалын

цэн нутаг 2010 он зуртал

8. Алтайн бүс, Түркийн хэвс орчимын бүс
- 8а. Алтайн бүс, Түркийн хэвс орчимын бүс
- 8б. Алтайн бүс, Түркийн хэвс орчимын бүс
- 8в. Алтайн бүс, Түркийн хэвс орчимын бүс
- 8г. Алтайн бүс, Түркийн хэвс орчимын бүс
- 7а. Алтайн бүс, Түркийн хэвс орчимын бүс
- 7б. Алтайн бүс, Түркийн хэвс орчимын бүс



зураг 16

## ХАДГАЛАН ХАМГААЛАХ ГАЗАР НУТГИЙН ТӨЛӨВЛӨЛТ



Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12

 ☎ 329612  
Индекс 14003

Хэвлэлийн хуудас 3.5

☎ 329487